

БОДЛОГЫН ЗОРИЛТУУДЫН ЗОРИЛТОТ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Бодлогын баримт бичгийн зорилтуудын зорилтот түвшинг дунд, богино хугацаанд тодорхойлох (цаашид “зорилтот түвшинг тодорхойлох” гэх)-д энэхүү аргачлалыг ашиглана.
- 1.2. Зорилтот түвшин тодорхойлох ажлын зорилго нь бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын зорилтот түвшинг дунд болон богино хугацаанд бодит байдалд үндэслэсэн, хүрч болохүйц байдлаар тодорхойлох, эдгээр дунд, богино хугацааны зорилтот түвшинд чиглэсэн бодлогын шийдлийг боловсруулан хэрэгжүүлэх, ингэснээр урт хугацааны бодлогын зорилго, зорилтыг биелэгдэх бодит боломжийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Зорилтот түвшинг тодорхойлох үндсэн дараалал

- 2.1. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт бүрийг шалгуур үзүүлэлтээр илэрхийлж, мэдээллийг эх сурвалжийг тодорхойлон, үзүүлэлт тус бүрд суурь түвшинг тооцно.
- 2.2. Шалгуур үзүүлэлтүүд тодорхойлогдсоны дараа зорилго, зорилтуудын зорилтот түвшинг нөхцөл байдлын шинжилгээг үндэслэн энэхүү аргачлалын 3 болон 4 дүгээр зүйлийн дагуу тогтооно.
- 2.3. Шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог тооцооллын загвар ашиглан гаргана.
- 2.4. Шалгуур үзүүлэлтийг өнөөгийн байдлаар хэмжих боломжгүй байгаа зорилтын хувьд манай улстай ойролцоо шинж бүхий улсын үзүүлэлтийг баримжаа болгон авч болно.

Гурав. Эцсийн зорилтот түвшин нь тодорхой байгаа үед завсрын зорилтот түвшинг тодорхойлох үе шатууд

- 3.1. Нэгдүгээр үе шатанд жилийн дундаж өөрчлөлт /өсөлт, бууралт/-ийн хувийг ашиглан жил бүр жигд өөрчлөлттэй нөхцөлд зорилтот түвшинг төсөөлнө. Үүний тулд одоогийн суурь түвшнээс зорилтот эцсийн зорилтот түвшин хүртэлх завсрын онуудын жилийн дундаж өөрчлөлтийн хувийг тооцно.
- 3.2. Хоёрдугаар үе шатанд үзүүлэлтийн өмнөх онуудын түвшний талаарх шаардлагатай нэмэлт судалгаа, тооцоог хийнэ. Зорилтот түвшинг тооцох явцад наад зах нь сүүлийн 10 жилийн уг үзүүлэлтийн өөрчлөлтийн талаарх нэмэлт судалгаа, тооцоог хийсэн байх бөгөөд дундаж өөрчлөлтийн хувийг тооцож гаргана. Өмнөх онуудын дундаж өөрчлөлтийн хувийг нэгдүгээр үе шатанд гаргаж авсан дундаж өөрчлөлтийн хувьтай харьцуулна.
- 3.3. Гуравдугаар үе шатанд жигд өөрчлөлтийн тооцоог бодит нөхцөлд аль болох тохируулан засварлана. Гадаад, дотоод бодит нөхцөл байдал, чиг хандлагыг харгалзан засвар өөрчлөлтийг ялангуяа дунд хугацааны төлөвлөлтийн хүрээнд зорилтот түвшинд тусгах шаардлагатай. Ялангуяа, томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бол зорилтот түвшинг уялдуулан өөрчлөх шаардлагатай.

3.4. Жилийн дундаж өөрчлөлтөөр баримжаалан зорилтот түвшинг тооцох боломжгүй үзүүлэлтийн хувьд, тухайн үзүүлэлтийн онцлогт тохируулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тодорхой төсөл, үйл ажиллагаанд үндэслэн тооцоо хийж, зорилтот түвшинг тооцно.

Дөрөв. Зорилтот түвшин нь тодорхой биш байгаа үед зорилтот түвшинг тодорхойлох үе шатууд

4.1. Нэгдүгээр үе шатанд өмнөх онуудын тоо мэдээлэлтэй үзүүлэлтийн хувьд олон жилийн (наад зах нь өмнөх 10 жилийн) өгөгдөлөөс жилийн дундаж өөрчлөлтийн хувийг тооцно. Өмнөх онуудын тоо мэдээлэл хангалттай байхгүй үзүүлэлтүүдийн хувьд тогтсон норм, нормативтай нөхцөлд түүнийг үндэслэн, эсвэл байгаа хугацааны өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан зорилтот түвшинг төсөөлнө. Зарим тохиолдолд хөгжлийн түвшин ойролцоо улс орнуудын дэвшүүлсэн зорилтуудын түвшинг харгалзан үзэж болно.

4.2. Хоёрдугаар үе шатанд өмнөх онуудын жилийн дундаж өөрчлөлтийн хувийг 3 хувилбараар (олон жилийн дунджаас доогуур, олон жилийн дундаж орчим, олон жилийн дундажаас дээгүүр) авч, суурь оноос эхлэн зорилтот түвшинг тооцно. Ингэхдээ жил бүр тогтмол өөрчлөлттэй байх нөхцөлөөр тооцоо хийнэ.

4.3. Гуравдугаар үе шатанд жигд өсөлт, бууралтаар хийсэн тооцоог бодит нөхцөлд аль болох тохируулан засварлана. Ингэхдээ тухайн салбарт дэвшүүлсэн тэргүүлэх чиглэл, бодлогын зорилтууд, үйл ажиллагааны төлөвлөсөн арга хэмжээ зэргийг харгалзан тухайн үзүүлэлтийн зорилтот түвшинг төсөөлнө. Тухайн үзүүлэлтэд хүчтэй нөлөөлөх бодлогын чанартай хийсэн интервенц буюу томоохон арга хэмжээний үр нөлөөг тухайн онуудад нь тусгаж өгнө. 3 хувилбараар хийсэн тооцоог бодит нөхцөлд аль болох тохируулан засварлах бөгөөд бодлого төлөвлөгч нь хувилбаруудаас сонголт хийн зорилтот түвшинг эцэслэн тооцно.